# ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ БОЛОН ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГАД ХАНДАЖ ГАРГАСАН ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ 2026 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ТАНИЛЦУУЛГА

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”, “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/66 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам"-ын хүрээнд тус яам болон түүний харьяа байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2026 оны эхний улирлын тайлан, дүн мэдээг танилцуулж байна.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон түүний харьяа байгууллагад 2026 оны эхний улирлын байдлаар нийт **515** өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлсэн байна. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг байгууллага тус бүрээр авч үзвэл:

1.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд 38;
2.Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газарт 2;
3.И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газарт 416;
4.Радио, телевизийн үндэсний сүлжээ улсын төсөвт үйлдвэрийн газарт 59;

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, болон Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв улсын төсөвт үйлдвэрийн газарт хандаж, өргөдөл, гомдол ирээгүй байна.

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд салбарын хэмжээнд эхний улирлын байдлаар нийт **515** өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн **512** буюу **99.4** хувь нь хянан шийдвэрлэгдэж, хариу өгөх хугацаа болоогүй 3 буюу 0.6 хувь судлагдаж байна. Өргөдөл, гомдлын тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад **76** буюу **13** хувиар буурсан байна.

Иргэд, олон нийттэй харилцах төв (11-11)-өөс шилжүүлсэн 75, бичгээр 1, утсаар 262, цахимаар 168, биечлэн 9 иргэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтээ илэрхийлсэн байна.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон түүний харьяа байгууллагууд нь иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-ийн хугацааг баримтлан иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг барагдуулж байна.

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 02/601 дүгээр албан бичгийн 4 дүгээр хавсралт

## ГОМДЛЫН АГУУЛГЫН 2026 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ТАЙЛАН

Оны эхнээс өссөн дүнгээр

| Чиглэл | Салбар | МД | Гомдлын тоо | Шийдвэрлэсэн тоо |
|---|---|---|---|---|
| А | Б | В | 1 | 2 |
| Барилга, хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөөний тухай | Барилга | 1 | | |
| | Хот төлөвлөлт | 2 | | |
| | Газар | 3 | | |
| Зам, тээврийн тухай | Авто зам | 4 | | |
| | Замын хөдөлгөөн зохицуулалт | 5 | | |
| | Нийтийн тээвэр | 6 | | |
| Эрчим хүчний тухай | Дулааны шугам сүлжээ | 7 | | |
| | Цахилгааны шугам сүлжээ | 8 | | |
| Орон сууц, нийтийн аж ахуй, сууц өмчлөгчдийн холбоо | Орон сууц, нийтийн аж ахуй | 9 | | |
| | Сууц өмчлөгчдийн холбоо | 10 | | |
| | Харъяаллын бус болон бусад асуудал | 11 | | |
| Нийтийн хэв журам, аюулгүй байдал | Онцгой байдал | 12 | | |
| | Цагдаа | 13 | | |
| | Шүүхийн шийдвэр гүйцэтгэл | 14 | | |
| | Хил хамгаалах | 15 | | |
| Төрийн үйлчилгээ, төрийн байгууллагын үйл ажиллагааны тухай | Төрийн байгууллага | 16 | | |
| | Төрийн үйлчилгээ | 17 | 21 | 21 |
| | Хяналт, шалгалт | 18 | | |
| | Архив | 19 | | |
| | Улсын бүртгэл | 20 | | |
| | Цэрэг татлагатай холбоотой | 21 | | |
| Шүүх, шүүхийн үйл ажиллагаа | Шүүхийн үйл ажиллагааны тухай | 22 | | |
| | Шүүхийн архивын үйлчилгээ | 23 | | |
| Төрийн албан хаагч | Төрийн албан хаагч | 24 | | |
| | Төрийн албан хаагчийн ёс зүй | 25 | | |
| Нийгмийн хөгжил, нийгмийн хамгааллын тухай | Аялал жуучлал | 26 | | |
| | Биеийн тамир, спорт | 27 | | |
| | Нийгмийн даатгал | 28 | | |
| | Нийгмийн халамж, үйлчилгээ | 29 | | |
| | Соёл урлаг | 30 | | |
| | Хөдөлмөр эрхлэлт | 31 | | |
| | Хүүхэд гэр бүл | 32 | | |
| | Эрүүл мэнд | 33 | | |
| | Дээд боловсрол | 34 | | |
| | Ерөнхий боловсрол | 35 | | |
| | Сургуулийн өмнөх боловсрол | 36 | | |
| Эдийн засаг, банк, | Санхүү, эдийн засаг | 37 | | |
| | Өмчийн харилцаа | 38 | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| санхүүгийн үйл ажиллагааны тухай | Нэмэгдсэн өргийн албан татварын цахим систем | 39 | | |
| | Татварын үйлчилгээ | 40 | | |
| | Гаалийн үйлчилгээ | 41 | | |
| Хүрээлэн буй орчин, тохижилт үйлчилгээний тухай | Агаарын бохирдол | 42 | | |
| | Байгаль хамгаалал | 43 | | |
| | Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн тохижилт | 44 | | |
| | Орчны бохирдол, хог хаягдал | 45 | | |
| Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний тухай | Хөдөө аж ахуй | 46 | | |
| | Мал эмнэлэг | 47 | | |
| | Үйлдвэрлэл | 48 | | |
| | Хүнс, худалдаа, үйлчилгээ | 49 | | |
| **Нийт дүн** | | **50** | 21 | 21 |